



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019. 03. 11 № 664

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН  
ДАРГА Г.ГАЛДӨЛ ТАНАА

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”  
онөтүг-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 26. хуудас.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бэлчээрийн мөнежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2019/9/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2019 он

Тэргүүлэх аудитор: Ж.Бямбажав  
Утас: 99085151 Цахим хаяг:byambaahunnu@yahoo.com  
Аудитын менежер: Г.Цэдэнбалжир  
Утас: 91991462 Цахим хаяг:dum\_audit@yahoo.com  
Аудитор: Н.Тэмүүжин  
Утас: 88103399 Цахим хаяг: dum\_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Няглан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## **Агуулга**

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Няглан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	12
3.1	Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.2	Цалингийн зардалтай холбоотой асуудал.....	13
3.3	Материалын данстай холбоотой асуудал .....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22



“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН ДАРГА  
Г.ГАЛДӨЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г.корпус, 5 давхар,  
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019. 03. 11 № 665

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ЫН 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохицой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ нь Няглан бodoх бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсэн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Галдөлд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дунд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийллээ.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02-р сарын 15-наас 2019 оны 03-р сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03-р сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Ж.Бямбажав, Н.Тэмүүжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2019 оны 02 сарын 15-ны өдрийн 05 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолоор “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг Австри улсын дэвшилтээт технологийн дагуу бэлчээрийн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг таримжуулан нутагшуулах замаар тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолоор Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтээт шинэ технологийг туршиж нэвтрүүлэх.
- Дээрх технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх.
- Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулах.
- Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрх дэвшилтээ технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан болно.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын удирдлага нь орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Няглан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, няглан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Няглан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийслэлийн 2018 оны төсөв баталсан Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол
- Газрын тухай хууль.
- Малын удмын сан түүний эрүүл мэндийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоолууд
- Нийслэлийн Засаг даргын холбогдох тогтоолууд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль

Тайлант хугацаанд “Малын генетик нөөцийн тухай” хууль батлагдан мөрдөгдөж эхэлсэн бөгөөд бусад бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## 2.5. Няглан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн няглан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус нэгжийн одоо мөрдөж байгаа Няглан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа няглан бодох бүртгэлийн бодлогын

**Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бodoх бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай гэж үзлээ. Үйл ажиллагааны цар хүрээ бага ажиллагсдын тоо цөөн байгаа нь дээрх үнэлгээнд нөлөөлсөн болно.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн 5 асуудалд нарийчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1,0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаа явуулдаг төсөвт үйлдвэрийн газрын хувьд зардлыг аль болох бага байхаар тооцож ажиллах шаардлагатай холбоотой юм.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны үйл ажиллагааны зардлын дун нь үр дүнгийн тайлангаар 376,740.1 мянган төгрөг бөгөөд түүний 1,0 хувь болох 3,767.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1,0 хувиар тооцсон нь үйл ажиллагааны орлогын гол эх үүсвэрийг төсвийн санхүүжилтээр бүрдүүлдэгтэй холбоотой юм.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг B201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг B401 маягаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 асуудалд горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад няглан бодох бүртгэлийн баримт бичгийг орлогод авалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн 3,800.0 мянган төгрөгийн гүйлгээг залруулан биет бус хөрөнгөөр санхүүгийн тайланд тусгуулан шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	3,747.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		3	3,747.1	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа зөрчилтэй асуудал байхгүй болно.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхан шатны баримтын бүрдэл хангахгүйгээр ажил гүйлгээг данс бүртгэлд тусгаж байгааг анхаарах шаардлагатай.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 251,754.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 238,190.9 мянган төгрөг буюу 94,6 хувьтай байгаа нь өөрийн үйл ажилгааны орлогоор 19358,5 мянган төгрөгийн зардлуудыг санхүүжүүлсэнтэй холбоотой гэж үзлээ.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны мэдээллийн санд жил, хагас жил, улирал, сараар болон тухай бүр оруулах мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланда аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн болно.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль,

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ  
ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ**

Соёлын төв өргөө, Амарын гудамж 2,  
Бага тойрог-1, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: 7011-2010

2019.03.05 № 11

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК-д □

Асуудлын бүртгэлтэй танилцан зөвшөөрч байна.  
Цаашид аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА

Г. ГАЛДӨЛ

2150300010

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангиин аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сүл талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт**

2018 оны 11-р сард "Ихэр гурван өндөр констракшн" ХХК-д шатахуун тээврийн хөлс гэж шилжүүлсэн 620.0 мянган төгрөгийн, 12 сард Ариунгэрэг Төрийн бус байгууллагад ажилчдын сургалтын төлбөрт гэж шилжүүлсэн 500.0 мянган төгрөгийн ажил гүйлгээнүүдэд анхан шатны баримтын бүрдэл хангахгүйгээр шууд зардлаар бүртгэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгасан байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж**

Гарсан алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх, анхан шатны баримтын бүрдлийг хангасан ажил гүйлгээг данс бүртгэлд тусгах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар**

Хүлээн зөвшөөрөв.

### **3.2 Цалингийн зардалтай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт**

2018 оны 8-р сарын цалин хөлсийг тооцоходо ажиллагсдын илүү ажилласан цагийг цагийн тодорхойлолтод бичилгүйгээр, "Илүү цагийн хөлс олгох тухай" байгууллагын даргын тушаалыг үндэслэн нийт 7 ажилтанд 1,495.4 мянган төгрөгийн илүү цагийн цалинг тооцон олгосон нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6 "Цагаар ажилласан ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагаар нь тооцож тухай бүр олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг тус тус зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгасан байх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж**

Анхан шатны баримтын бүрдлийг хангасан ажил гүйлгээг данс бүртгэлд тусгах

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар**

Хүлээн зөвшөөрөв.

### **3.3 Материалын данстай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт**

Түлш, шатах тослох материалын 2018 оны 5,7,10,12-р сарын тайлангуудад жолоочийн тооцооны хуудасны бүртгэлгүй 1,131.7 мянган төгрөгийн шатахуун илүү зарлагадсан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланда тусгахыг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна.

#### **3.3.2 Эрсдэл**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгасан байх

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж**

Гарсан алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх, анхан шатны баримтын бүрдлийг хангасан ажил гүйлгээг данс бүртгэлд тусгах

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар**

Хүлээн зөвшөөрөв.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудитын байгууллагад 2019 оны 06-р сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Хянасан:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Бэлтгэсэн:

АУДИТОР



Ц.БАТ-ӨЛЗИЙ

Д.ОТГОНБАЯР



Ж.БЯМБАЖАВ

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланийн аудит

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>79,594,221.50</b>	<b>127,386,144.28</b>
<b>31</b>	<b>МОНГОН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	00.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,102,000.00	2,103,402.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	15,402.32
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,102,000.00	2,088,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	00.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	11,673.46
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	11,673.46
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	72,492,221.50	125,271,068.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	35,229,216.63	27,091,359.43
35110	Тусгай зориулалттай материал	35,229,216.63	27,091,359.43
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	16,393,502.87	35,234,221.08
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,869,502.00	29,585,487.99
35410	Бичиг хэргийн материал	407,870.00	595,570.00
35420	Аж ахуйн материал	2,499,130.00	3,830,238.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	824,600.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	102,440.00
35470	Бусад хангамжийн материал	17,962,502.00	24,232,639.99
35600	Мал амьтад	00.00	33,360,000.00
